

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021.12.25

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, байгууллагын стратеги төлөвлөгөө, 2021 онд дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх чиглэлээр 2021 онд дараахь ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэлээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 216 арга хэмжээний гүйцэтгэл 2020 онд 68.7 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн 12 дугаар сарын 9-ний өдрийг Олон улсын авлигын эсрэг өдөр хэмээн зарлан тунхаглаж, 2021 онд тухайн өдрийг “Таны эрх, Таны оролцоо: Авлигад үгүй гэж хэлье” уриан дор дэлхий нийтээр тэмдэглэхээр болсонтой холбогдуулан “Авлигын эсрэг үндэсний чуулган-2021” арга хэмжээг “Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа”, “Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоо”, “Төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэхэд анхаарах асуудал”, “Хувийн хэвшил ба шударга өрсөлдөөн” гэсэн 4 салбар хуралдаантайгаар зохион байгууллаа.



ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, “Транспэрэнси Интернэшнл” зэрэг олон улсын байгууллагуудын төлөөлөл, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монголд Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, Франц Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, Канад Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Монгол Улсад суугаа бусад орны Элчин сайдууд, хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, гадаадын зочид төлөөлөгчид зэрэг 300 орчим хүн оролцлоо.

Үндэсний чуулганы нээлтэд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх илгээлт илгээж, Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар оролцож, авлигатай тэмцэх чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлогын талаар үг хэлэв.

Чуулганаар бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдын хүсэл зоригийг сонсож, цаашид шийдвэрлэх асуудлыг тодорхойлж, судлаач эрдэмтдийн санал дүгнэлтийг хэлэлцсэн ач холбогдол бүхий арга хэмжээ боллоо.

Монгол Улсын Засгийн газраас Авлигын индексийн үзүүлэлтийг сайжруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө баталсан бөгөөд тус ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн даргаар тус газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал томилогдон ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэхэд хувийн хэвшлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, бизнесийн ёс зүйг төлөвшүүлэх чиглэлээр МҮХАҮТ-тай, “egazar” программд мэдээллийг нэгтгэх буюу интеграци хийх, зарим аймгийн газар олгох үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай, “UB-engineering” буюу орон зайн мэдээллийн нэгдсэн системд төрийн байгууллагын цахим мэдээллийг оруулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж байна.

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг эмхэтгэн Монгол Улсын Улсын Их Хурал, Монгол улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд болон холбогдох бусад байгууллагад хүргүүлэв.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт нэр бүхий албан хаагчид ажиллаж байна.

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй”, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилт 87.0 хувь буюу “Сайн”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны хэрэгжилт 96.0 хувь буюу “Бүрэн хангалттай” үнэлэгдлээ. 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,150.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, Сангийн Яамны төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn цахим системд үйл ажиллагааны мэдээллийг цаг хугацаанд тогтмол хөтөлж, 1,141.1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлснээр 2021 оны худалдан авах ажиллагаа бүрэн хэрэгжлээ. 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн мэдээллээр гүйцэтгэл 99.2 хувьтай байгаа нь нийт Төсвийн ерөнхийлөн захирагч нараас хамгийн өндөр хэрэгжилттэй гэж үнэлэгдэн нэгдүгээрт эрэмбэлэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны хэрэгжилтийг хянаснаар хэрэгжилт 96.0 хувь буюу “Бүрэн хангалттай”, Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдлээ.

Хоёр.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

2.1 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд-Нийслэлийн Амгалан амаржих газар, Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнд ажиллаж төрийн байгууллагын

үйлчилгээ авахад үүсч буй хүнд суртал, чирэгдлийн тухай нэгтгэн үнэлэлт, дүгнэлт хийж, байгууллагын авлигын эсрэг хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийв.

Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн Өргөө амаржих газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн харьяа байгууллагууд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Баян-Өлгий, Дорнод аймаг, Цагдаагийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт, зөрчил арилгуулах албан бичгийн мөрөөр Үндэсний музей, Чингис Хааны музейд ажиллав.

Ийнхүү ажиллахдаа авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах чиглэлээр гүйцэтгэсэн ажил, арга хэмжээтэй танилцаж, дүн шинжилгээ хийх, зарим зөрчлийг газар дээр нь арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүллээ.

Зам, тээвэр хөгжлийн яам, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт ажилласан бөгөөд тайлан мэдээг нэгтгэн боловсруулах ажил үргэлжилж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгч, ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг дагаж мөрдөх, багшийн мэргэжлийн нэр хүндийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн сургууль болон гэр бүлээр дамжуулан сурагч, эцэг эх, багш нарт авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад туслах зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 12, 24, 32, 40, 84 дүгээр сургуульд “Шударга ёсны клуб”-ыг байгуулж, үйл ажиллагааг албан ёсоор нээж, шаардлагатай тоног төхөөрөмж, “Багшийн ёс зүйн дүрэм” самбар болон сургалтын ном, гарын авлага, сурталчилгааны материалыг хүлээлгэн өгөөд байна.



2.2 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;” чиг үүргийн хүрээнд-Орон тооны бус салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээний санал, чиглэлийг хүргүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хамтарч ажиллах талаар санал солилцож, нэгдсэн мэдээлэл арга зүйгээр хангах зорилгоор уулзалт зохион байгуулав.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралдаанд оролцож, Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд, мөн Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн 2021 оны төсөв, төлөвлөгөөний төсөлд авлигын эсрэг болон авлигаас урьдчилан сэргийлэх ажил, үйл ажиллагааны саналыг тусгуулсан.



Аймгийн Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 37 ажилтныг авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийн 5 удаагийн сургалтад хамруулж, гэрчилгээ олгон сургагч багш нараас 2021 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын нэгдсэн жишиг төлөвлөгөөг боловсруулж, 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэв. Цагдаагийн байгууллагын албан хаагчдаас 2019 онд сургагч багшаар бэлтгэгдсэн 64 албан хаагчийн ажлын тайланд дүн шинжилгээ хийн, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулав.



Архангай, Хөвсгөл, Дархан-Уул, Баян-Өлгий, Сэлэнгэ, Баянхонгор, Дорнод аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн арга хэмжээний биелэлтэд дүн шинжилгээ хийв.

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Авлигагүй нийгмийн төлөө Хамтдаа” 1 сарын аяныг дэмжин чиглүүлж, арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.


Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас иргэд, олон нийтэд зориулан бүтээсэн авлигын эсрэг шторк, видеог 12 телевизээр 2 сарын турш нэвтрүүлж, авлигын эсрэг постерыг гудамж талбай, автобусны талбайд байрлах 37 самбарт, Нийслэлийн 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний 4 төвд мэдээллийн самбар тус тус байршуулан түгээж, сурталчлах ажлыг зохион байгуулав.

2.3 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. дэхь хэсэгт заасан “төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;” чиг үүргийн хүрээнд-авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах чиглэлээр 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. Үүнд:

Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид, их, дээд сургуулийн болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарыг оролцуулан “Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүүхэд, залууст шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрт шударга ёсны хандлага, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга туссан байдалд хийсэн дүн шинжилгээтэй танилцаж, илтгэл хэлэлцүүлж, санал бодлоо хуваалцлаа.



Транспарэнси интернэшнл Монгол ТББ-тай хамтран 2020 онд зохион байгуулсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт ажилласан үр дүн буюу тухайн үйл ажиллагааны эрх зүйн орчин, үйл ажиллагаа, албан хаагчдыг ажлын ур чадвар, хүртээмж, хамрагдалтын талаарх тайланг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын дарга, удирдлагыг оролцуулан 2020, 2021 онд эдгээр байгууллагуудад хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн



мөрөөр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнг хэлэлцэх хэлэлцүүлэг хийлээ. Энэ нь мөрдөгчийн мэдэгдлийн үр дүнгийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хийсэн анхны уулзалт болсноороо онцлог байлаа.

Нээлттэй нийгэм форум, Монголын тогтвортой хөгжил нийгмийн хариуцлагын зөвлөлтэй хамтран УУХҮЯ, СЯ, ХЗДХЯ, ХААГ, ТӨБЗГ, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд, “Мон-Атом” ХХК, “Хил хязгааргүй алхам” ТББ, “Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо” зэрэг төрийн бус байгууллага, холбоодын төлөөлөл, судлаачдыг оролцуулан “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, шилэн данс, худалдан авах ажиллагааны төлөвлөлт болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж гаргалаа.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг татан оролцуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн, нийгэмд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын удирдлага, төлөөллийг оролцуулан “Авлигын эсрэг хамтын ажиллагаа: Төрийн бус байгууллагын оролцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгээр авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд иргэдийг татан оролцуулах, сургаж чадавхижуулах, соён гэгээрүүлэх ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх, санал санаачилгыг өрнүүлэхэд төрийн бус байгууллагууд идэвхтэй оролцохыг уриалав.


“Бодлогод залуусын оролцоо”, “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” болон “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагуудтай хамтран улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагуудын худалдан авалтын дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний ил тод байдалд иргэдийн зүгээс хяналт тавих арга зүйд сургах, үр дүнтэй хяналт, оролцоог төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Орон нутгийн төсвөө хяная-BudgeThon” хакатоныг зохион байгуулав.

Дата эрх чөлөө: Мэдэх эрх” дата, гэрэл зураг, түүх хосолсон үзэсгэлэнг “Бодлогод залуусын хяналт ТББ”, “Тунгаахуй” өгөгдлийн урлан зэрэг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа. Нээлттэй өгөгдлийг ашиглан олон нийтийн зүгээс төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих боломж, арга хэлбэрийн талаар олон нийтэд ойлголт өгөх, энэ хүрээнд иргэний нийгмийн зүгээс гаргасан санал, санаачилгыг сурталчилсан үр дүнтэй арга хэмжээ болов.

2.4 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дэх хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд-Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Гаалийн ерөнхий газрын дарга, Хавдар судлалын үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал, Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Онцгой комиссоос батлан гаргасан 18 дүрэм, журамд авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал үүсгэх эрсдэл байгаа эсэхийг судалж, өөрчлөх, хүчингүй болгуулах талаар санал боловсруулж хүргүүлэв. Энэ хүрээнд тус газраас авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал бий болгох, бусдад давуу байдал болгох эрсдэл бүхий гэж үзэж хүчингүй болгуулах санал хүргүүлснээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 173 дугаар тушаалаар баталсан “Монгол Улс болон БНХАУ-ын хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд зорчих зөвшөөрлийн бичиг олгох журам”, Нийслэлийн Өргөө амаржих газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/23 дугаар “Жагсаалт, журам батлах тухай” /төлбөртэй тусламж, үйлчилгээ/ тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсон байна.

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д заасны дагуу төрийн байгууллага, салбарын хэмжээнд мөрдөх 13 ёс зүйн дүрмийн төсөл, зарим хуулийн этгээдийн Ёс зүйн зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж, санал хүргүүллээ.

2.5 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараахь ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилгоор “Аавын захиас”, “Тангараг” “Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр”, “Шударга ёс гэж юу вэ?” сэдэвт богино хэмжээний 4 кино контент, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утасыг сурталчилсан 2 төлийн шторкыг бүтээв.



“Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020” эмхэтгэл, Авлигын гэмт хэргийг 2013, 2015, 2016, 2017 онд хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, “Зөв зөвд шударга зөв”, “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч танаа”, “Засаг дарга танаа”, Шударга ёсны боловсрол /авлигатай тэмцэх, үнэт зүйлс болон хууль дээдлэх талаар боловсрол олгох нь/ OECD гарын авлага, 4 төрлийн сурталчилгааны материал, 6 төрлийн зурагт хуудсыг эрхлэн хэвлүүлж, сургалт, сурталчилгааны ажилд ашиглуулахаар төв, орон нутаг, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж номын сангуудад түгээж ажиллалаа.

Авлигын хор хөнөөл, шударга зүйлд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зорилгоор зорилтот бүлгүүдэд зориулсан видео контент, цахим хуудас, пэйжээр, телевизүүдтэй хамтран түгээхийн зэрэгцээ 38 төрлийн зурагт хуудас, постер, плакат, тараах материалыг бэлтгэн хэвлүүлж, орон сууц, гудамж талбай, бусад байгууллагын цахим хуудаст байршуулж, сурталчилах, түгээх ажлыг зохион байгуулж байна.

Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, иргэдийн оролцоог хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг хүргэх зорилгоор Монголын үндэсний олон нийтийн радиогийн АТГ-ын 1.10 хөтөлбөр, Инээмсэглэл фм 99.3, Kiss fm 100.1, Монголчуудын радио 102.1, Таны радио 103.6, Эрүүл амьдралын радио 104, Гэр бүлийн радио 104.5, MGL 88.3, орон нутгийн FM 89.1 радиотой хамтран ажиллаж байна.

“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Шинэ үе авлигыг тэвчихгүй” цахим илтгэлийн уралдааныг зохион байгуулав. Уралдаанд 150 сурагч оролцсоноос 6 сурагчийг шалгаруулж, илтгэлээс постер хийж түгээн сурталчилав.


Хүүхэд багачуудад бага наснаас нь шударга ёсны талаар ойлголт өгөх, шударга үйлдэл, дадал хэвшилтэй болгох



зорилгоор Улсын Хүүхэлдэйн театрт хамтран “Бүлтээхэй, дэлдээхэй хоёрын шударга тоглоом” теле жүжгийг бүтээж, олон нийтийн хүртээл болгов. Хүүхэд, багачуудад шударга ёсны үнэ цэнийг ойлгуулах, үнэт зүйлээ тодорхойлоход туслах, аливаа зүйлийн зөв, бурууг ялган таних, улмаар зөв хүмүүжил, зөв дадлыг бий болгох, үе тэнгийнхэндээ шударга ёсны үзэл бодлоо хуваалцах, нийгэмд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Зөв дадал-21” арга хэмжээ, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга ёсны боловсрол олгох, түүнд эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэх зорилгоор “Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил” чөлөөт




уулзалтыг зохион байгууллаа. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол улсын боловсролын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Соёл урлагийн их сургууль, Монгол улсын их сургууль, Улаанбаатар их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль зэрэг Их, дээд сургуулийн оюутнуудад шударга ёсны талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, авлигын эсрэг дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх зорилгоор “Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” нээлттэй өдөрлөгийг 4 үе шаттай зохион байгуулав.



Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлтэй хамтран “Иргэдэд зориулсан нээлтэй өдөрлөг”-ийг нийслэлийн 8 байршилд хийлээ. Арга хэмжээний үеэр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг 1158 иргэнд сурталчилж, 70 иргэнээс өдөрлөгийн талаарх санал, сэтгэгдлийг сонсож, 14 төрлийн нийт 8184 танилцуулга, ном, гарын авлагыг иргэдэд түгээж, иргэдийн дунд АХА тэмцээн зохион байгуулсан нь иргэдэд байгууллагын үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээ, мэдээлэл хүргэсэн, авлигын талаарх мэдлэг мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлсэн ач холбогдол бүхий үйл ажиллагаа боллоо.



Иргэдтэй харилцах 110 мэдээллийн аппликэйшнийг playstore, appstore-д байршуулж, нийт 124 мэдээ мэдээлэл оруулж, туршилт хийсэн бөгөөд нийт хандалт 5724 удаа, сард дунджаар 585 удаагийн хандалт хийгдсэн байна. Тус аппликэйшнээр дамжуулан иргэдээс санал асуулга авах өргөн боломж бүрдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар туршилтын журмаар 6 санал асуулга оруулаад байна.



Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх агуулга бүхий мэдээлэл агуулсан “Шударга ёс, хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарыг Монгол Улсын 12 яам, 36 агентлагт, “Багшийн ёс зүйн дүрэм” самбарыг Нийслэлийн боловсролын газар, 9 дүүргийн боловсролын хэлтэстэй хамтран төрийн өмчийн 148, төрийн бус 127, нийт 275 сургуульд байршуулах ажлыг зохион байгуулав.



Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 134 удаа зохион байгуулж, 341 иргэн, 27304 нийтийн албан тушаалтан, нийт 27645 хүнийг хамруулав. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хийх сургагч багш нарыг чадавхижуулж, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилт тавьсанаар орон нутгаас бэлтгэгдсэн сургагч багш нар 4480 хүнд, “Шударга ёсны боловсрол” хөтөлбөрийн хүрээнд



бэлтгэсэн ЕБС-ийн багш нар нийт 20892 хүүхэд, 332 эцэг эхэд буюу нийт 25704 иргэн, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эцэг эхэд сургалт зохион байгуулсан байна. Авлигын эсрэг сургалтад хамрагдсан нийт хүний тоо өмнөх оноос 2 дахин, нийтийн албан тушаалтны тоо 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Видео шторк, контентуудыг арилжааны 12 телевиз, орон нутгийн 24 телевиз, “Авлигатай тэмцэх газар” болон “АТГ-Олон Нийтийн Төв” пэйж хуудсууд болон “IAAC Mongolia youtube” хуудсаар дамжуулан түгээж, олны хүртээл болгов. “Авлигатай тэмцэх газар” пэйж хуудасны дагагчдын тоо 4104-аар, “АТГ-Олон нийтийн Төв” пэйж дагагчдын тоо 10126-аар, “IAAC Mongolia youtube” хуудас захиалагчдын тоо 67.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор багш нарын оролцсон 5, эдийн засагчдын оролцсон 10, ардын уран зохиолчын оролцсон 3, телевизийн нэвтрүүлэгч нарын оролцсон 4, богино хэмжээний кино, клип 9, сэтгүүлчдийн оролцсон 15, нийт 46 видео, контент, шторк бүтээж, олон нийтийн сүлжээ, радио, телевизээр тасралтгүй сурталчлан түгээж ажиллалаа.

2.6 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

- “Их, дээд болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Монгол улсын Ерөнхий сайдад;

- Дорнод аймгийн албан ёсны цахим хуудсанд хийсэн үнэлгээнд үндэслэн ил тод байдлыг хангах талаар тус аймгийн Засаг даргын Тамгын газарт;

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын газарт ажилласан дүнд үндэслэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд;

- Олон улсын ачаа тээврийн “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад,

- “Их, дээд болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан шударга ёсны хандлагыг төлөвшүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Монгол улсын Ерөнхий сайдад;

- Дорнод аймгийн албан ёсны цахим хуудсанд хийсэн үнэлгээнд үндэслэн ил тод байдлыг хангах талаар тус аймгийн Засаг даргын Тамгын газарт;

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын газарт ажилласан дүнд үндэслэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд;

- Олон улсын ачаа тээврийн “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зам, тээврийн хөгжлийн сайдад;

- Авлигын гэмт хэрэг үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдад;

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад;

- Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах, мөрдөгчийн мэдэгдлийн гүйцэтгэлийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газарт тус тус зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Төрийн байгууллагын цахим хуудасны мэдээллийн ил тод байдалд үнэлгээ хийх аргачлалыг баталж, төрийн байгууллагуудын цахим хуудсанд үнэлгээ хийх ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Дээрх аргачлалын дагуу яам, агентлаг, 21 аймгийн болон нийслэлийн 9 дүүргийн цахим хуудасны ил тод, нээлттэй байдалд үнэлэлт дүгнэлт хийж, зөвлөгөө өглөө.

Гурав. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр:

Төрийн байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв, Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Зээлийн батлан даалтын сан, Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Хөдөө аж ахуйг дэмжих сан, Шинжлэх ухаан технологийн сан, Замын Үүд дэх гаалийн газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар /14/-т гэрээгээр гүйцэтгүүлэв. Эрсдэлийн үнэлгээгээр дээрх байгууллагуудын үйл ажиллагаа, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн чиглэлийн үйл ажиллагаа, байгууллагын удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, бүртгэл хөтлөлтөд авлигын эрсдэлийн түвшин өндөр үнэлэгдсэн. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад авлигын эрсдэлийн тайланг танилцуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлөө.

“Шударга байдлын үнэлгээ”-ний 2021 оны судалгааг гүйцэтгэж, дүнг танилцуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулав. Шударга байдлын үнэлгээнд 2021 онд 46 яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 68 байгууллагыг хамруулсан. Тооцооллоор Шударга байдлын үнэлгээ 72.9 гарсан нь 2019 оныхоос 1.2 пунктээр буурсан байна. Шударга байдлын үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгууллаа.

Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа”-г хийлээ. Судалгаагаар 2021 онд улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 3.82 пункт, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 3.85 пункт гарсныг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 0.16 пунктээр буурч, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин өмнөх оны үзүүлэлтээс 0.03 пунктээр өссөн байна.

Хүүхдийн шударга байдлын 2021 оны судалгааг аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 8080 сурагч, 1169 багш, албан хаагч, 1968 эцэг, эхээс мэдээлэл цуглуулан хийж, судалгааны үр дүн, тайланг боловсруулав. Судалгаагаар хүүхдийн шударга байдлын түвшин 4.06 гарсан нь өмнөх оноос 0.05 пунктээр нэмэгдсэн байна. Судалгааны дүнг олон нийтэд танилцуулсны дээр судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургууль, Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт тус тус хүргүүлэв.

“Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгаа”-г нийслэлийн 9 дүүргийн иргэдээс түүврийн дагуу биечлэн уулзах, харилцаа холбооны хэрэгслээр холбогдон асуулга асуух зэргээр 4067 өрхийг хамруулан хийлээ.

- ✓ Хорооноос иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хороонд хандаж үйлчилгээ авсан иргэдийн талаарх судалгаа;
- ✓ “Авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах”;
- ✓ “Монголчуудын ёс заншил, уламжлал, ахуй, соёлтой нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох”;
- ✓ “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны стратеги (2022-2024) боловсруулах”;
- ✓ “Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаарх олон нийтийн санаа бодлыг судалж, дүгнэлт, зөвлөмж санал боловсруулах (хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх)” ;
- ✓ “Монгол Улс дахь авлигад нөлөөлж буй хүчин зүйлийн динамик загвар боловсруулах нь” судалгааны ажил тус тус үргэлжилж байна.

Бусад улс орнуудад авлигын гэмт хэрэгт оногдуулж байгаа эрүүгийн хариуцлага Авлигын төсөөллийн индексийн оноотой хамааралтай эсэхийг тогтоох зорилгоор 33 улсын эрүүгийн хуульд тусгагдсан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний харьцуулсан судалгаа, Монгол Улсын төрийн байгууллагын цахим хуудасны мэдээллийн хүртээмжтэй байдлын судалгааг тус тус хийж, хоблогдох саналын хамт эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Бусад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээг зохих журмын дагуу хийлээ.

“Шударга ёс” онол, арга зүйн цувралын 2021 оны эхний хагас жилийн дугаарыг бэлтгэн хэвлүүлж, түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулав.

Дөрөв. Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:


4.1 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүнг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2021 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 117 байгууллагын 43692 /цахимаар-38947, хэвлэмэл байдлаар-4745/ мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 100 хувь мэдүүлгээ гаргаж баталгаажуулсан.

2020 онд Монгол Улсын Соёлын яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Үндэсний геологийн алба, Биеийн тамир, спортын улсын хороо, Төрийн тусгай хамгаалалтын газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар зэрэг Засгийн газрын яам, агентлаг шинээр болон өөрчлөн зохион байгуулагдсан, Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 275 дугаар тогтоолоор төрийн захиргааны, 276 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбоотой мэдүүлэг гаргасан албан тушаалтны тоо өмнөх оноос 2006 нэгжээр нэмэгдсэн байна.


ХАСХОМ-ээ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын 13445 буюу 31.0 хувь нь төрийн тусгай, 11050 буюу 25.0 хувь нь төрийн захиргааны, 7741 буюу 18.0 хувь нь улс төрийн, 5700 буюу 13.0 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 2743 буюу 6.1 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах, 1091 буюу 3.0 хувь нь ажлын албаны, 201 буюу 0.5 хувь нь төрийн өндөр албан тушаалтан болон Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг, 1721 буюу 4 хувь нь бусад албан тушаалтнууд тус тус эзэлж байна.

Хүснэгт 1 ХАСХОМ гаргасан албан тушаалтан /төрийн албан тушаалын ангиллаар/



Нийт мэдүүлэг гаргагчийн 23302 буюу 55.0 хувь нь Улаанбаатар хотод, 18384 буюу 45.0 хувь нь орон нутагт, мөн 12102 буюу 29.0 хувийг ахлах мэргэжилтэн, болон удирдах, 29583 буюу 71.0 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан эзэлж байна. Орон нутгаас Хөвсгөл аймгаас 1308 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлт болж байна.

Хүснэгт 2 ХАСХОМ мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн тоо /аймгаар/



Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс үзэхэд 484 албан тушаалтан “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 36677 албан тушаалтан “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл”, 333 нь “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан байна.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2020 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.hachom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

4.2 Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр болон бусад албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар-Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад 314 албан тушаалтнаас /3 албан тушаал сул байсан./ албан үүргээ гүйцэтгэж байгаа нийт 311 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд шинэчлэн гаргасан.

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад албан тушаалд шинээр томилогдсон, сонгогдсон 158 албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлгээ бүртгүүлж, 26 албан тушаалтан хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлснийг хуулийн хугацаанд хүлээн авч, хяналт тавин ажиллалаа.

4.3 Сонгуульд нэр дэвшигчин хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар-Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчээс хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар мэдүүлсэн тохиолдолд гаргах “Баталгааны маягт”-ын загварыг шинэчилж, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хүлээн авах, мэдээлэх ажлыг хариуцан зохион байгууллаа. Сонгуулийн ерөнхий хороотой хамтран “Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч танаа” гарын авлагыг боловсруулан нэр дэвшигчдийг мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллалаа.

4.4 Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар-Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем “<https://meduuleg.iaac.mn>”-д бүртгэгдсэн мэдүүлэгт цахим системээр дамжуулан хяналт тавих, нэгдсэн байдлаар дүн шинжилгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хөгжүүлэх шаардлагаар Дэлхийн банкны “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хяналт шалгалтыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга (СтАР)-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн Дэлхийн банкны шинжээчийн тайлан болон холбогдох бусад баримт бичигт тулгуурлан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт эрсдэл тооцох аргачлал”-ыг боловсруулав. Уг аргачлалаар албан тушаалтны мэдүүлсэн ХАСХОМ-т 28 бүлэг 50 орчим үзүүлэлтээр эрсдэл тооцох боломжтой болов. Аргачлалын дагуу 2019-2020 онд мэдүүлэг гаргасан 40.0 мянга гаруй албан тушаалтны мэдээлэлд эрсдэл тооцоноос 8292 албан тушаалтан эрсдэлтэй гэсэн тооцоо гарсан. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мэдүүлэг гаргагчийн хүрээг оновчтой тогтоох, ХАСХОМ, ХАСУМ, мэдэгдлийн маягт, мэдүүлгийн цахим системийг боловсронгуй болгох, төрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах үүрэг

бүхий эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ын үйл ажиллагаанд тулгарч буй асуудал, цаашид Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох зорилгоор улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 737 эрх бүхий албан тушаалтнаас холбогдох судалгааг авч, тайланг нэгтгэн боловсруулав. Судалгааны үр дүнг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05, 20 дугаар тогтоолыг боловсронгуй болгох үйл ажиллагаанд ашиглаж байна.

4.5 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтын талаар-Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин, нийт 77 компанийн ажилтнуудын ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийж, төсөв, хөрөнгө захиран зарцуулах, тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид төрийн тодорхой үйлчилгээг хэрэгжүүлэх бие даасан нэгжийг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах, гэрээ байгуулах, хяналт шалгалт явуулах, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах зэргээр шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа удирдах болон эрх бүхий албан тушаалтныг тодорхойлов. Эдгээр ажилтнуудаас эрсдэл бүхий 404 албан тушаалтан байгааг тогтоож, эдгээрийг Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамруулж, мэдүүлэг гаргавал зохих удирдах болон эрх бүхий тушаалтнаар тодорхойлох талаарх зөвлөмжийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, УБТЗ, “Эрдэнэс тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, түүний харьяа байгууллагуудад хүргүүлэв.

Мэдүүлэг гаргагчийн хөрөнгө орлого нь 1 тэрбум, түүнээс дээш хэмжээгээр өссөн болон давтамжтайгаар өсч байгаа 24 албан тушаалтны цэвэр хөрөнгийн байдалд харьцуулсан дүн шинжилгээ хийж, ийнхүү мэдүүлсэн мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн гишүүдийн татварын орлогтой нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Татварын ерөнхий газартай хамтран ажиллаж байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Монголын Цахилгаан холбоо” ХК, “Монголросцветмет” ТӨҮГ, “Монголын төмөр зам” ТӨХК-иудад мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт явуулснаар ХАСХОМ-ийг хугацаа хожимдуулсан, хуулийн хугацаанд мэдүүлээгүй зэрэг зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэв.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх хэсгийн 4.1.1.4-д тусгагдсан “төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлыг төрийн өндөр албан тушаалтан болон улс төрийн намын нөлөөллөөс ангид байлгах” ажил, арга хэмжээний хүрээнд төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч /тэргүүлэгч/-дийн судалгааг хийлээ. Судалгаагаар 2020 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүнгээр сонгогдсон 8052 төлөөлөгчөөс 1072 /13.3 хувь/ нь нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулснаас 64 /6.0 хувь/ нь төрийн жинхэнэ албан тушаал (төрийн захиргаа, төрийн тусгай)-д томилогдон ажиллаж байна. Тус судалгааны дүнг үндэслэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

4.6 Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар-Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, гаргаж байгаа нийтлэг зөрчил, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг дээшлүүлэх, удирдах албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулав. 2021 оны байдлаар Төрийн болон нутгийн захиргааны төв болон тэдгээрийн салбар нэгж 118 байгууллагад ажиллаж байгаа ЭБАТ-ын судалгааг шинэчлэн хийлээ. Судалгаагаар улсын хэмжээнд нийт 1792 ЭБАТ ажиллаж байгаагаас 191 буюу 10.6 хувь нь энэ онд шинээр томилогдсон байна.

ЭБАТ-уудыг мэдээлэл, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор нийтийн сүлжээнд цахим нэгдсэн групп үүсгэн гарын авлага, зөвлөмж, мэдээлэл,

зааварчилгаа, сурталчилгаа болон бусад цаг үеийн шинжтэй мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж, тэднээс ирүүлсэн асуулт, санал, хүсэлтэд хариулт өгч ажиллаж байна.

УИХ-ын Тамгын газрын албан хаагчид, УИХ-ын гишүүдийн зөвлөх, туслах, Эрүүл мэндийн яам болон түүний харьяа байгууллагууд, Баянгол дүүргийн Татварын хэлтэс, Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид зэрэг 508 албан тушаалтанд, шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудад 2 удаагийн сургалт зохион байгуулснаар давхардсан тоогоор 203 албан хаагч хамрагдсан байна.

Хүснэгт 3 Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлт




Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаарх сурталчилгааны шторкыг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор МҮОНТ, ТВ-9, Монгол HD зэрэг телевиз, Өдрийн сонин, Өнөөдөр сонин болон АТГ-ын цахим сайт, www.news.mn, www.ikon, www.medee.mn сайтуудтай хамтран ажиллав.

4.7 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт, шалгалтын ажлын талаар-Тайлант хугацаанд шинээр хүлээн авсан 337, өмнөх оны үлдэгдэл 35, нийт 372 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгахаас 315 /93.5/-г хянан шийдвэрлэж, 57 мэдүүлэг ажиллагаанд байна.


Нийт шалгасан мэдүүлгийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хүлээн авсан мэдүүлгийн тоо 218 /555/ нэгжээр буюу 39,2 хувиар, хянан шийдвэрлэсэн мэдүүлэг 227/542/ нэгжээр буюу 41,8 хувиар буурсан, шийдвэрлэлт 93.5 хувьтай байна.

Хүснэгт 4 Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт /өмнөх оны мөн үетэй харьцуулбал/



Тайлант хугацаанд шалгасан нийт мэдүүлгийн 257 буюу 81.5 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 11 буюу 3.4 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 47 буюу 14.8 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.

**Хүснэгт 5 Мэдүүлгийн хяналт шалгалт хийсэн үндэслэл
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/**



Төлөвлөгөөт хяналт шалгалтын хувьд “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 13, “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 14, “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 10, нийт 37, ТӨХК, ТӨХХК-ийн нийт мэдүүлэг гаргагчаас эрсдэл бүхий 35, бусад 28 мэдүүлэг гаргагчийн 2016-2020 оны ХАСХОМ-т хяналт шалгалт хийлээ.

Хяналт шалгалтаар 94 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 48 нэгжээр буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6 Шалгасан ХАСХОМ болон хариуцлага тооцуулсан тоон үзүүлэлт

Он	ХАСХОМ					Хариуцлага тооцуулсан байдал
	Өмнөх оны үлдэгдэл	Тайлант хугацаанд хүлээж авсан	Шалгавал зохих	Шалгаж шийдвэрлэсэн	Үлдэгдэл	
2020	22	555	577	542	35 /6,3/	46
2021	35	337	372	315	57 /15,3/	94

Хяналт шалгалтаар 5 мэдүүлэг гаргагчийн хувь эзэмшдэг хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогын байдал нь татвараас зайлсхийж татварын тайланг үнэн зөв гаргаагүй байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон тул уг асуудлыг Татварын ерөнхий хууль, Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр шалгуулахаар эрх бүхий байгууллагад, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үндэслэлээр 22 мэдээллийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэст шилжүүллээ.


4.8 Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар-2021 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 560 /өмнөх оны үлдэгдэл 40/, нийт 600 гомдол, мэдээллийг хянан шалгах агаас тайлант хугацаанд 561 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд 39 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт 93.5 хувьтай байна.

Энэхүү үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал, хүлээн авсан гомдол мэдээлэл 104 нэгжээр 14,7 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 55 буюу 9.0 хувиар тус тус буурсан, шийдвэрлэлт 6.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хянан шалгасан гомдол, мэдээллээс 90 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, үүнээс 30 албан тушаалтанд сахилгын шийтгэл тооцуулж, үлдэх хувьд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, зөрчилтэй захиргааны актыг хүчингүй болгуулах зэргээр шаардлага, зөвлөмжийг хүргүүлэв.

Хуульд заасан үндэслэлээр буцаасан 28, гэмт хэргийн шинжтэй гэж үзэж шилжүүлсэн 74, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 108, гомдлоо буцаасан 14, зөрчил илрээгүй 191, бусад 30 байна.

**Хүснэгт 7 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
/өмнөх оны мөн үетэй харьцуулбал/**



Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар нийт гомдол гаргагчдын 67,2 хувьд албан бичгээр, 32,7 хувьд нь амаар хариу өгсөн байна.

Тайлант хугацаанд хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 237 буюу 39,5 хувийг Улаанбаатар хотоос, 363 буюу 60,5 хувийг орон нутгаас ирүүлсэн байна.

Тоон үзүүлэлт, мэдээллээс харахад аймгуудаас Баян-Өлгий 12.5, Архангай 3.7, Дундговь, Дорноговь аймаг тус бүр 3.0 хувийг эзэлж байгаа нь бусад аймгаас өндөр үзүүлэлт болж байна.

Шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулгын хувьд албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн 21,0 хувийг, албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон бусдад давуу байдал олгосон 19.0 хувийг, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр гаргасан 23.0 хувийг, хууль бус томилгоо хийсэн 27.0, бусад зөрчил 10.0 хувийг тус тус эзэлж байна.

Энэхүү үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон болон ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан байдал тус бүр 2,0 хувиар, албаны эрх мэдлээ урвуулсан хэтрүүлсэн зөрчил, хууль бус томилгоотой холбоотой зөрчил тус тус 3,0 хувиар өссөн байна.

Хяналт шалгалтын явцад хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн боловсролын газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 52 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

4.9 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан талаар: Тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 12504 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 12468 этгээдэд хамаарах урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 36 мэдүүлэг хянагдаж байна.

Хүснэгт 8 Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг


	Хүлээн авсан	Хянасан	Үүнээс:				Үлдэгдэл
			АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх	Хуульд зааснаар буцаасан	
2020 онд	13151	13030	11684	848	8	489	121 /0.7/
2021 онд	12504	12468	11162	1018	22	266	36 /0.3/

2021 онд хүлээн авсан ХАСУМ-ийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 647 нэгжээр буюу буурсан боловч шийдвэрлэлт 0.7 хувиар өсч, ажиллагааны үлдэгдэл 85 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

Тав. Мөрдөн шалгах ажлын талаар:

5.1 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл-Байгууллагын хэмжээнд 2021 онд өмнөх оны 105, энэ оны 1491 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, нийт 1596 гомдол, мэдээллийг хүлээн авснаас 329 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 234 нэгжээр буюу 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9 Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл




Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл: төрийн улс төрийн 233, төрийн захиргааны 427, төрийн тусгай 594, төрийн үйлчилгээний 148, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 194 байна.

Хүснэгт 10 Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1144 гомдол, мэдээллээс 460 гомдол, мэдээлэл буюу 40.2 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 594 гомдол, мэдээлэл буюу 51.9 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 44 гомдол, мэдээлэл буюу 3.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 46 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.0 хувьтай байна.

Хүснэгт 11 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1144 гомдол, мэдээллийн 676 буюу 59,1 хувь нь Нийслэлийн, 648 буюу 40,9 хувь нь орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай байна.

5.2 Эрүүгийн хэргийн талаар-Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1543 үйлдэлтэй, 909 холбогдогчтой, 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1,8 хувиар буурсан байна. /2020 онд 1331/


Нийт шалгасан хэргийн 269 буюу 20.6 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 429 буюу 32.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 61 буюу 4.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 63 хэргийг нэгтгэн шалгаж, 5 хэргийг түдгэлзүүлж, одоо 480 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 399 хэрэг, мөрдөн байцаалтын 81 хэрэг байна.

2020 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1331 хэргээс 236 буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж байсан бол 2021 онд 1307 хэргээс 269 хэргийг буюу 20,6 хувийг шилжүүлсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2.9 хувиар өсч, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 62.9 хувьтай байгаа бөгөөд шүүхээр 160 хэрэг буюу 42,4 хувь нь эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Хүснэгт 12 Хэргийн шийдвэрлэлт



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал: Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/ гэмт хэрэг-820 буюу 53.1 хувь,

Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Хахууль авах/ гэмт хэрэг-225 буюу 14.6 хувь, Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/ гэмт хэрэг-134 буюу 8.7 хувь,

Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ гэмт хэрэг-20 буюу 1.3 хувь,

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/ гэмт хэрэг-36 буюу 2.3 хувь,

Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ гэмт хэрэг-26 буюу 1.7 хувь,


Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/ гэмт хэрэг-33 буюу 2.1 хувь,

Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэрэг-24 буюу 1.6 хувь,

Бусад хэрэг 225 буюу 14.6 хувийг тус тус эзэлж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 91 буюу 10.0 хувийг төрийн улс төрийн, 149 буюу 16.4 хувийг төрийн захиргааны, 145 буюу 15.9 хувийг төрийн тусгай, 175 буюу 19.3 хувийг төрийн үйлчилгээний, 349 буюу 38.4 хувийг хувийг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, хэвшлийн аж ахуйн нэгжийн албан тушаалтан, иргэн эзэлж байна.


Хүснэгт 13 Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан



2021 онд шалгасан гэмт хэргийн улмаас 1,002,100,805, 191 /нэг их наяд, 2 тэрбум, нэг зуун сая, найман зуун таван мянга нэг зуун ерэн нэг/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 96,207,070,220 /ерэн зургаан тэрбум, хоёр зуун долоон сая, далан мянга, хоёр зуун хорь/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 119,502,691,958 /нэг зуун арван есөн тэрбум, таван зуун хоёр сая, зургаан зуун ерэн нэгэн мянга, есөн зуун тавин найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 14 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



5.3 Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар: 2020 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 114 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн бол 2021 онд 160 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг өмнөх оныхоос 40.3 хувиар өссөн байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг дурдвал:

Улсын их хурлын гишүүн асан Эрдэнэс монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа нарт холбогдох, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргаар ажиллаж байсан Р.Энхтайванд холбогдох, Хууль зүйн яамны газрын даргаар ажиллаж байсан Б.Үнэнбат, Ховд аймаг дахь цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан Ц.Ганболд, "Өгөөжтэй өв" ХХК-ны захирал М.Чинбат нарт холбогдох, "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирал Ч.Чинбатад холбогдох, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор Ш.Нямдоржид холбогдох, Гадаад харилцааны яамны болон Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын нэр бүхий албан тушаалтнуудад холбогдох "Дипломат-95"-ын гэх хэрэг, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дашцэрэн, "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн судалгааны мэргэжилтэн Т.Байгалмаад холбогдох, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл, Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-ын гүйцэтгэх захирал А.Гантулга, Бэрэн групп ХХК-ийн захирал Б.Мөнхтөр нарт холбогдох, Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газрын Санхүү, захиргааны албаны дарга А.Мартад холбогдох, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Орлого, шимтгэлийн тасгийн дарга Б.Эрхэмбаяр, Хяналт, шалгалт дотоод аудитын тасгийн дарга Н.Алтантуяа нарт холбогдох, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд бүтцийн хяналтын хэлтэст барилгын техникийн хяналтын улсын байцаагч Т.Батцэнгэлд холбогдох хэргүүд анхан шатны шүүхээр, Монгол Улсын Ерөнхий сайд асан М.Энхсайхан, Улсын их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, Б.Батзориг, Салхитын мөнгөний ордны хэрэг буюу шүүгч Б.Цолмонбаатар нарт холбогдох зэрэг хэргүүд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр тус тус шийдвэрлэгдээд байна.

2021 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн 160 хэргийн шийтгэх тогтоолоос 116-г хүлээн аваад байгаа бөгөөд ийнхүү хүлээн авсан тогтоолоос үзэхэд мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан болон битүүмжлэн хамгаалсан хөрөнгөөс шүүх 1,444,012,295 төгрөгийг улсын орлого болгохоор шийдвэрлэж 821,780,000 төгрөгийн торгуулийн ял оногдуулсан байна.